



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

“Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын
2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшний болон контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон захирал Б.Наран-Идэртэй байгуулсан 2018 оны контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэртэй 2019 онд 1 жилийн хугацаатай контракт байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн болон зорилтот түвшний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД

0000455